


ШУТИС-ийн Ректорын 2025 оны 03 дугаар сарын  
28-ны өдрийн А/88 дугаар тушаалын хавсралт



	<b>ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРТ ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ ШУТИС-СҮ-ЖУ11</b>	Эхний хэвлэлт	1991.05.01
		Өөрчилсөн огноо	2025.03.28
		Өөрчлөлтийн дугаар	36

**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН  
БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРТ ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ  
(2025-2026 оны хичээлийн жил)**

**Боловсруулсан:**

**СУРГАЛТЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН АЛБА**

**Хянасан:**

**СУРГАЛТ, ОЮУТНЫ ХӨГЖИЛ ЭРХЭЛСЭН ПРОРЕКТОР**

**Дэмжсэн:**

**ШУТИС-ИЙН РЕКТОРЫН ЗӨВЛӨЛ**

**Баталсан:**

**ШУТИС-ийн РЕКТОР**



## АГУУЛГА

АГУУЛГА.....	2
НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.....	3
ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ.....	3
ГУРАВ. НОРМАТИВ ЭШЛЭЛ.....	3
ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ.....	3
ТАВ. ЭРХ МЭДЭЛ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА.....	4
ЗУРГАА. ЭЛСЭЛТИЙН КОМИСС.....	6
ДОЛОО. БҮРТГҮҮЛЭГЧИД ТАВИХ ШААРДЛАГА.....	6
НАЙМ. ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛ.....	8
ЕС. УР ЧАДВАРЫН ШАЛГАЛТ.....	9
АРАВ. ОНООНЫ ЖАГСААЛТ, ЭРЭМБЭЛЭЛТ.....	9
АРВАН НЭГ. ХӨТӨЛБӨР СОНГОЛТ, БАТАЛГААЖУУЛАЛТ.....	10
АРВАН ХОЁР. ЭЛСЭГЧИЙН БҮРТГЭЛ.....	11
АРВАН ГУРАВ. ЭЛСЭГЧДЭД ОЛГОХ ТЭТГЭЛЭГ.....	12
АРВАН ДӨРӨВ. БУСАД.....	14
ХАВСРАЛТ 1. БАКАЛАВРЫН ҮНДСЭН ХӨТӨЛБӨРИЙН ЖАГСААЛТ.....	15
ХАВСРАЛТ 2. ХАМТАРСАН ХӨТӨЛБӨРИЙН ЖАГСААЛТ.....	24
ХАВСРАЛТ 3. БАЙРШИЛ, ХАЯГИЙН МЭДЭЭЛЭЛ.....	28



## **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт элсэн суралцахаар хүсэлт гаргагч, элсэлтийн ажлыг удирдан зохион байгуулах элсэлтийн комиссын үйл ажиллагаатай холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.
- 1.2. Боловсролын Яамнаас тогтоосон шаардлага, дээд боловсролын сургалтын орчны болон холбогдох стандартад нийцүүлэн сургуулийн Удирдах Зөвлөлөөс баталсан хяналтын тоонд багтаан ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт оюутан элсүүлнэ.

## **ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ**

- 2.1. Энэхүү журам нь ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт 2025-2026 оны хичээлийн жилд элсэгчийг бүртгэх, ур чадварын шалгалт авах, оноогоор эрэмбэлэх, хөтөлбөр сонголт хийлгэх, баталгаажуулах, элсүүлэх үйл явцыг тус тус хамарна.

## **ГУРАВ. НОРМАТИВ ЭШЛЭЛ**

- 3.1. Дээд боловсролын тухай хуулийн 18 дугаар зүйл;
- 3.2. Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 29-ны 115 дугаар “Хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэл батлах” тухай тогтоол;
- 3.3. Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 6-ны 102, 103 дугаар тогтоол;
- 3.4. Боловсролын сайдын 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/66 дугаар тушаалаар батлагдсан “Элсэлтийн шалгалт зохион байгуулах журам”, 2025 оны 02 дугаар сарын 14-ний “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/69 дугаар тушаал;
- 3.5. Боловсролын сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/143 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт “Оюутан элсүүлэх журам”, хоёрдугаар хавсралт “Элсэлтийн хяналтын тоог тогтоох аргачлал”;
- 3.6. Боловсролын сайдын 2024 оны 03-р сарын 20-ны өдрийн А/146 дугаар “Мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индекс шинэчлэн батлах тухай” тушаал;
- 3.7. Боловсролын сайдын 2024 оны 03-р сарын 20-ны өдрийн А/147 дугаар “Нийтлэг шаардлага шинэчлэн батлах тухай” тушаал;
- 3.8. Боловсролын сайдын 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/228 дугаар “Босго оноог тогтоох тухай” тушаал.

## **ДӨРӨВ. НЭР ТОМЬЁНЫ ТОДОРХОЙЛОЛТ**

- 4.1. Элсэлтийн шалгалт (цаашид ЭШ гэх) гэж Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад дэд бакалавр, бакалаврын хөтөлбөрт элсэн суралцагчид суралцахад шаардагдах сурах ерөнхий чадвар, мэдлэгийн түвшин тогтоох шалгалтыг;
- 4.2. Монгол хэл бичгийн шалгалт (цаашид МХБШ гэх) гэж эх хэлний боловсролын чанар, хэрэглээ, иргэдийн харилцааны соёл, эх хэлний дархлааны түвшин тогтоох монгол хэл, бичгийн шалгалтыг;
- 4.3. Ур чадварын шалгалт гэж зарим хөтөлбөрийн дагалдах хичээлд тооцох, ШУТИС-аас зохион байгуулах нэмэлт шалгалтыг;
- 4.4. Элсэлтийн комисс гэж элсэлтийн үйл ажиллагааг удирдлагаар хангах, зохион байгуулахаар томилогдсон ажлын хэсгийг; (Комисс нь төв ба дэд, салбар комисс гэсэн хэлбэртэй байна)



- 4.5. Ур чадварын шалгалтын комисс гэж ур чадварын шалгалтыг зохион байгуулахаар томилогдсон ажлын хэсгийг;
- 4.6. Хяналтын тоо гэж удирдах зөвлөлөөс баталсан хөтөлбөрт элсүүлэх суралцагчийн тоог;
- 4.7. Элсэлтийн систем гэж элсэлтийн цахим бүртгэлийн системийг;
- 4.8. Элсэлтийн бүртгэл гэж элсэлтийн веб хуудсанд нэвтэрч хувийн мэдээллийг оруулан, элсэх хүсэлтэй хэд хэдэн хөтөлбөрийг сонгож, цахимаар төлбөр төлж баталгаажуулах үйл явцыг;
- 4.9. Бүртгүүлэгч гэж дээд боловсролын сургалтын байгууллагад элсэх хүсэлт гаргасан иргэнийг;
- 4.10. Хөтөлбөр сонголт, баталгаажуулалт гэж ШУТИС-ийн тухайн сургалтын хөтөлбөрт тохирох хичээлүүдээр ЭШ өгсөн бүртгүүлэгч босго онооны болзол ханган, онооны жагсаалтын дагуу хөтөлбөр сонгон, баталгаажуулах үйл явцыг;
- 4.11. 1 багц цагийн төлбөр гэж сургуулийн Удирдах зөвлөлөөс тогтоосон тухайн хичээлийн жилд мөрдөх 1 багц цаг (кредит)-ийн төлбөрийг;
- 4.12. Элсэгч гэж хяналтын тоонд багтан элсэх эрхээ баталгаажуулсан бүртгүүлэгчийг;
- 4.13. Гадаадын иргэн гэж Монгол Улсын иргэний харьяалалгүй буюу гадаад улсын иргэний харьяалалтай хүнийг;
- 4.14. Зэргийн бус сургалт гэж иргэнд тодорхой чиглэлээр мэдлэг, боловсролоо дээшлүүлэх боломж олгох, боловсролын зэрэг олгохгүй сургалтыг;
- 4.15. Т гэж тэргүүлэх чиглэлийн хөтөлбөрийг;
- 4.16. Э гэж эрэлттэй чиглэлийн хөтөлбөрийг;
- 4.17. Журамд дурьдсан ШУТИС-ийн бүрэлдэхүүн, харьяа сургуулийн товчилсон нэрийг хүснэгт 1-д үзүүлснээр хэрэглэнэ.

Хүснэгт 1.

д/д	Сургуулийн нэр	Товчлол
1	Барилга, архитектурын сургууль	БАС
2	Гадаад хэлний сургууль	ГХС
3	Геологи, уул уурхайн сургууль	ГУУС
4	Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль	ДаТС
5	Механик инженер, тээврийн сургууль	МИТС
6	Менежментийн сургууль	МС
7	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	МХТС
8	Нийгэм, хүмүүнлэгийн сургууль	НХС
9	Хүнс, хөнгөн үйлдвэрлэл, дизайн сургууль	ХХҮДС
10	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	ХШУС
11	Эрчим хүчний инженерчлэлийн сургууль	ЭХИС
12	"Эрдэнэт цогцолбор" дээд сургууль	ЭЦДС
13	Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургууль	ӨмТДС

## ТАВ. ЭРХ МЭДЭЛ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

### 5.1. ШУТИС-ийн Ректор

5.1.1. Элсэлтийн комиссыг тушаалаар батална.

5.1.2. Элсэлтийн үйл ажиллагааны явцтай танилцаж санал, зөвлөмж өгнө.



- 5.1.3. Элсэлтийн үйл ажиллагааны үр дүнгийн тайлангаар танилцаж үнэлэлт, дүгнэлт өгнө.
- 5.2. **Элсэлтийн төв комисс**
- 5.2.1. Элсэлтийн үйл ажиллагааг удирдлагаар ханган, ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлнэ.
- 5.2.2. Элсэлтийн явцад хяналт тавих болон элсэлттэй холбоотой бусад үйл ажиллагааг зохицуулна.
- 5.2.3. Ур чадварын шалгалт зохион байгуулах комиссыг байгуулж ажиллуулна.
- 5.2.4. Элсэлтийн маркетингийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.
- 5.2.5. Элсэлтийн үеийн өргөдөл гомдлыг хүлээн авч барагдуулна.
- 5.3. **Элсэлтийн дэд комисс**
- 5.3.1. Элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, бүрэлдэхүүн сургууль дээр ажлын төлөвлөгөө, төсөв гаргаж, батлуулан хэрэгжүүлнэ.
- 5.3.2. Элсэлттэй холбоотой боловсролын үзэсгэлэнгийн үйл ажиллагаа, хөтөлбөрүүдийг нийтэд танилцуулах ажлыг зохион байгуулна.
- 5.3.3. Элсэлтийн явцад хяналт тавих болон элсэлттэй холбоотой бусад үйл ажиллагааг зохицуулна.
- 5.4. **Элсэлтийн салбар комисс**
- 5.4.1 ШУТИС-ийн ДаТС, ШУТИС-ийн харьяа ЭЦДС, ӨмТДС-ийн сургуульд элсэлтийн салбар комисс байгуулж 5.2, 5.3-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 5.5. **Сургалтын бодлого, зохицуулалтын алба**
- 5.5.1. Элсэлтийн журам боловсруулж, батлуулна.
- 5.5.2. Элсэлтийн төв комисс, дэд комиссын бүрэлдэхүүн, ажлын төлөвлөгөөг боловсруулж батлуулна.
- 5.5.3. Элсэлтийн дэд, салбар комиссын үйл ажиллагаанд хяналт тавьж хамтран ажиллана.
- 5.5.4. Элсэлттэй холбоотой үндсэн үйл ажиллагааг зохицуулах, шаардлагатай бичиг баримтууд боловсруулах, оролцогч талуудыг мэдээллээр хангах үүрэг хүлээнэ.
- 5.5.5. Элсэлтийн үйл ажиллагааны үр дүнгийн тайланг бэлтгэж, захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.
- 5.6. **Мэдээллийн технологийн төв**
- 5.6.1. Цахим элсэлтийн бүртгэл, хуваарь сонголтын программ хангамжийг шинэчлэн хөгжүүлнэ.
- 5.6.2. Бүртгүүлэгчдийг мэдээллээр хангах гар утасны аппликейшн программд бэлтгэсэн мэдээллийг оруулах, шинэчлэх ажлыг хариуцна.
- 5.6.3. Элсэлтийн веб сайтад холбогдох мэдээллийг оруулах, шинэчлэх ажлыг гүйцэтгэнэ.
- 5.6.4. Цахим элсэлтийн программ хангамжийн найдвартай, хэвийн ажиллагааг хангана.
- 5.6.5. Сервер, тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангана.
- 5.7. **Захиргааны удирдлагын газар**
- 5.7.1. Элсэлтийн үйл ажиллагаатай холбоотой сурталчилгааны материал бэлтгэх, хөтөлбөрүүдийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээгээр сурталчлах ажлыг зохион байгуулна.



- 5.7.2. Элсэлттэй холбоотой боловсролын үзэсгэлэнгийн үйл ажиллагаа, хөтөлбөрүүдийг нийтэд танилцуулах асуудлаар элсэлтийн комисстой хамтран ажиллана.
- 5.7.3. Бүрэлдэхүүн, харьяа сургуулиудын элсэлтийн маркетинг, сурталчилгааны ажилд дэмжлэг үзүүлнэ.
- 5.7.4. Элсэлтийн маркетингийн үйл ажиллагааг тайлагнана.
- 5.8. **Эрүүл мэндийн төв**
- 5.8.1. Шинээр элсэгчдэд эрүүл мэндийн даатгал, түүний ач холбогдол, хэрхэн хамрагдах талаар танилцуулга, мэдээлэл хүргэнэ.
- 5.8.2. Шинээр элсэгчдийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулна.
- 5.9. **Бүрэлдэхүүн, харьяа сургууль**
- 5.9.1. Хөтөлбөрийн талаарх цахим болон хэвлэмэл танилцуулга материал боловсруулж түгээх, мөн бусад хэлбэрээр хөтөлбөр сурталчлах ажлыг зохион байгуулна.
- 5.9.2. Хөтөлбөр хариуцаж байгаа салбар, тэнхимүүд хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүдэд элсэгчдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор тусгайлан ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх ба энэ үйл ажиллагаанд багшлах бүрэлдэхүүнийг татан оролцуулна.
- 5.9.3. Шинэ элсэгчтэй суралцах гэрээг цахимаар байгуулан зөвлөх багш, сургалтын албаар дамжуулан сургалтын үйл ажиллагааг танилцуулж, хичээл сонголтыг зохион байгуулна.
- 5.10. **Бүртгүүлэгч, Элсэгч**
- 5.10.1. ШУТИС-ийн элсэлтийн журам, элсэгчдэд зориулсан вэб хуудас, бусад материалтай танилцаж элсэлтийн үйл ажиллагаа, зохион байгуулалтын талаар мэдээлэл авна.
- 5.10.2. Элсэлтийн бүртгэлийн системд хувийн мэдээллээ үнэн зөв оруулж, өөрийн сонирхсон хөтөлбөрүүдээс сонгон бүртгүүлнэ.
- 5.10.3. Босго онооны болзол хангасан бүртгүүлэгч цахим элсэлтийн системээр дамжуулан хөтөлбөр сонголт хийж, заасан хугацаанд баталгаажуулна.
- 5.10.4. Хөтөлбөр баталгаажуулалт хийсэн элсэгч сонгосон хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа бүрэлдэхүүн, харьяа сургуультай суралцах гэрээг цахимаар байгуулна.

## **ЗУРГАА. ЭЛСЭЛТИЙН КОМИСС**

- 6.1. ШУТИС-ийн элсэлтийн төв комисс, дэд комисс болон ур чадварын шалгалтын комиссыг ШУТИС-ийн ректорын тушаалаар, харьяа сургуулийн элсэлтийн салбар комиссыг тухайн сургуулийн захирлын тушаалаар тус тус батална.
- 6.2. Элсэлтийн төв комиссын дарга нь элсэлтийн үйл ажиллагааг удирдлагаар хангаж ажиллах бөгөөд тухайн журмаар зохицуулагдаагүй асуудлыг бүрэлдэхүүн/харьяа сургуулийн саналыг үндэслэн комиссын хурлаар хэлэлцэж, шийдвэрлэнэ.

## **ДОЛОО. БҮРТГҮҮЛЭГЧИД ТАВИХ ШААРДЛАГА**

- 7.1. ШУТИС-ийн бакалаврын сургалтад элсэн суралцах хүсэлтэй, ЭШ өгсөн бүртгүүлэгч дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:
- 7.1.1. Бүрэн дунд ба түүнээс дээш боловсролтой байх;